



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/40

Бат-Өлзий сум

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зөрүүлэг 4 дүгээр багийн нутаг дэвсгэр “Яргайт” гэх газар нутаглаж байгаа малчин Г.Батцэнгэлийн 1 үхэрт мал, амьтны халдварт галзуу өвчний шинж тэмдэг илэрч Мал эмнэлгийн тасгийн 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 1 дүгээр саналаар 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн 14 хоног хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт байгаа тухайн хот айлын 37 толгой бод, 463 толгой бог малыг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулж, ариутгал халдваргүйжүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг “Хутагт уулын өгөөж” Мал эмнэлгийн малын их эмч (П.Содномбалжир), Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч (Ж.Булганзаяа), 4 дүгээр багийн Засаг дарга (Г.Пүрэвтогтох) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Холбогдох заавар журмын дагуу хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ), уг захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (П.Аюушжав), Цагдаагийн тасгийн дарга, (цагдаагийн хошууч Д.Энх-Амгалан) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН